

2022 оны 12 дугаар сарын 08-ны өдөр

ЗӨВЛӨХИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ХҮСЭЛТЭЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД

Шинжээч сонгон шалгаруулах урилга хүргүүлэх тухай

Үндэсний аудитын газар нь "Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн 2020-2021 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудит"-ын хүрээнд "Газрын тосны өртөг нөхөх зардлыг баталгаажуулах аудитын зөвлөх үйлчилгээ үзүүлэх" шинжээч сонгон шалгаруулж, гэрээ байгуулан хамтран ажиллах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хуулийн этгээдийг саналаа ирүүлэхийг урьж байна.

Энэхүү үйл ажиллагаа нь Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам"-ын дагуу хэрэгжих бөгөөд сонгон шалгаруулалтад оролцогч этгээдийн санал нь санал хүлээн авахаар товлосон өдрөөс эхлэн 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Шинжээчийг сонгох урилга нь дараах бүрдэл хэсгүүдтэй. Үүнд:


- Ажлын даалгавар
- Саналын баримт бичиг

Шинжээч нь **ҮАГ-АД/22-040** дүгээр ажлын даалгаварт тусгасан ажлыг аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу ажлын даалгаварт заасан ажлыг АДБОУС, Бүтээгдэхүүн хуваах гэрээ, хууль, журам болон бусад баримт бичигт нийцүүлэн цаг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэх үүрэгтэй бөгөөд, ажлын зорилтын хүрээнд Үндэсний аудитын газар, Ашигт малтмал, газрын тосны газар болон Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн ажлын байранд ажиллаж, бэлтгэсэн ажлын баримт материалд тулгуурлан аудитын гүйцэтгэлийн болон тайлагналын үе шатны шаардлагатай мэдээллээр дэд тайлан бэлтгэж, тайлан дүгнэлтийг 30 хоногийн хугацаанд багтаан аудитын багт хүлээлгэн өгнө.

Сонирхсон этгээд нь Ажлын даалгавар, "Шинжээч сонгох саналын баримт бичиг" бусад холбогдох мэдээллийг www.audit.mn цахим хаягаас болон ҮАГ-ын Захиргаа, хууль, эрх зүйн газрын худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Н.Цэнд-Аюушаас авч болно. Ажлын утас: 51-261745, гар утас: 88051068.

Саналыг файл хэлбэрээр info@audit.gov.mn, tsend-ayushn@audit.gov.mn цахим шуудангаар 2022 оны 12 дүгээр сарын 16-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө ирүүлнэ үү.

Захиалагчийн хаяг: Үндэсний аудитын газар-15160. Улаанбаатар хот. Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын IV байр.



(Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн 2020-2021 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх)

**ГАЗРЫН ТОСНЫ ӨРТӨГ НӨХӨХ ЗАРДЛЫГ
БАТАЛГААЖУУЛАХ АУДИТАД ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ
/АУДИТ ГҮЙЦЭТГЭХ ХУУЛИЙН ЭТГЭЭД/-ИЙН
АЖЛЫН ДААЛГАВАР**

2022 оны 11 дүгээр сарын
15-ны өдөр

Дугаар
122-040

Улаанбаатар
хот

Ажлын зорилго: Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулдаг Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн 2020-2021 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитыг гүйцэтгэж, гэрээлэгчийн газрын тосны бүтээгдэхүүний борлуулалт, бүтээгдэхүүн хуваалт, өртөг нөхөгдөх зардлын тайланг Бүтээгдэхүүн хуваах гэрээ, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид заасан шаардлага, шалгуурыг ханган, үнэн зөв тайлагнасан эсэхэд дүгнэлт өгөхөд оршино.

Ажил гүйцэтгэх хугацаа: 2022.12.12-2023.01.15

Байршил: Үндэсний аудитын газар

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3, 17 дугаар зүйлийн 17.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Үндэсний аудитын газар (цаашид “захиалагч” гэх) Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн 2020-2021 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад аудит хийж баталгаажуулна.

ХОЁР. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ, ҮҮРЭГ

Аудитыг гүйцэтгэх хуулийн этгээд нь Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу ажлын даалгаварт заасан ажлыг АДБОУС, Бүтээгдэхүүн хуваах гэрээ, хууль, журам болон бусад баримт бичигт нийцүүлэн цаг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэх үүрэгтэй.

Ажлын зорилтын хүрээнд Үндэсний аудитын газар, Ашигт малтмал, газрын тосны газар болон Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн ажлын байранд тус тус ажиллана. Бэлтгэсэн ажлын баримт материалд тулгуурлан ажлын даалгаварт тусгасан ажлыг гүйцэтгэж, аудитын гүйцэтгэлийн болон тайлагналын үе шатны шаардлагатай мэдээллээр дэд тайлан бэлтгэнэ. Үүнд:

1. Гэрээлэгчийн олборлосон тосны хэмжээ /баррель/, Экспортолсон газрын тосны хэмжээ /баррель/, Борлуулалтын орлогын хэмжээ /ам доллар/, Борлуулалтын зардлын дүн, тоо хэмжээг тус тус баталгаажуулна.

Гүйцэтгэх ажил: Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн 2020-2021 оны олборлосон газрын тос, экспортын газрын тосны хэмжээг дараах тоо хэмжээ, баримтад тулгуурлан баталгаажуулалт хийнэ. Үүнд:

Олборлолт:

- Олборлолтын төлөвлөгөө, гүйцэтгэл;
- Олборлолтын цооногуудаар олборлосон газрын тосны хэмжээ;
- Цооног шавхалтаар олборлосон тосны хэмжээ;
- Ус шахалтын үйл ажиллагаанд хэрэглэсэн ус.

Экспорт:

- Экспортолсон тосны ачилтын хэмжээ;
- Экспортолсон тосны буулгалтын хэмжээ;
- Усны агууламж, нягтын хэмжээ, тонн жин.

Протокол, олборлолтын өдөр тутмын мэдээ, ус шавхалтын өдөр тутмын мэдээ, анхан шатны баримт, гаалийн мэдээлэл зэрэг санхүүгийн баримт материалуудыг ашиглан дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн 2020-2021 оны борлуулалтын орлогын журналыг нэхэмжлэх, дансны хуулгатай тулган шалгах;
- АМГТГ-аас 2020-2021 оны олборлосон, экспортолсон газрын тосны хэмжээ, боруулалтын орлого бүрдүүлэлт зэрэгт хяналт тавьсан эсэхийг тулган шалгах.

2. Орд ашиглалтын үйл ажиллагаатай холбоотой хөрөнгө оруулалтын зардал, үйлчилгээ, бараа материал, цалин, даатгал, оффис, бааз агуулахын зардал, Үйл ажиллагаа, тээвэр, борлуулалт, хуулийн болон өртөг нөхөгдөх зардлын тайланд тусгасан бусад зардлыг баталгаажуулна.

Гүйцэтгэх ажил:

2.1. Хөрөнгө оруулалтын зардал: Орд ашиглалтын ерөнхий төлөвлөгөө, жилийн ажлын хөтөлбөр, төсөв, гүйцэтгэл, өртөг нөхөх зардлын тайланг анхан шатны баримттай тулган шалгана. Үүнд:

- Анхан шатны баримтын шалгалт хийх;
- Тооцооллыг шалгах;
- Жишиг үнийн харьцуулалт хийх;
- Гэрээний гүйцэтгэл шалгах;
- Асуудлын бүртгэл болон өгсөн маягтын дагуу ажлын баримт бэлтгэж нэгтгэх.

2.2. Цалин, даатгалын зардал: Жилийн ажлын хөтөлбөр, төсөв, гүйцэтгэл, өртөг нөхөх зардлын тайланг анхан шатны баримттай тулган шалгана. Үүнд:

- Өртөг нөхөх зардлын тайланд тусгасан цалин, даатгалын зардлыг анхан шатны баримттай тулган баталгаажуулах;
- Анхан шатны баримтад тусгасан Монгол, Хятад ажилтнуудын цалингийн тооцооны хүснэгтээс цалингийн тооцоолол, нэмэгдэл, урамшууллын үндэслэлийг давтан тооцоолж, тулган баталгаажуулах;
- Цагийн бүртгэл, ажилд томилсон, чөлөөлсөн тушаал шийдвэрийн үндэслэлийг анхан шатны баримтад үндэслэн тулгах;
- Монгол, Хятад ажилтнуудын цалингаас Хувь хүний орлогын албан татварын тухай, Нийгмийн даатгалын тухай хуулиудын дагуу суутгасан хувь хүний орлогын албан татварын болон нийгмийн даатгалын шимтгэлийн суутгалыг тулган баталгаажуулах;
- Тус компани нь 2020-2021 онд БНХАУ-аас хичнээн иргэнийг хөдөлмөр эрхлүүлэхээр Монгол Улсад оруулж ирснийг холбогдох судалгаатай тулгах, /YAГ тус судалгааг Хөдөлмөр, халамж, үйлчилгээний ерөнхий газраас авч өгөх/

- Дээрх Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн нэр дээр хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авч орж ирсэн БНХАУ-ын иргэдийн хөдөлмөрийн харилцаа, цалин хөлсний үндэслэл, татвар, даатгалын харилцаа нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг тогтоох;
- Удирдлагын зардалд хамаарах өөрөөр хэлбэл Монгол Улсад түр ажилласан, толгой компанид бүртгэлтэй ажилтнуудад тус компаниас олгосон цалингийн зардлыг өртөг нөхөн зардлаас хасаж тооцох;
- Монгол Улсын болон БНХАУ-ын ажилтнуудын цалинг тооцож олгож байгаа журам, шийдвэр нь Газрын тосны тухай хуульд хэрхэн нийцэж байгаа талаар тулган шалгаж, дүгнэлт гаргах;
- Асуудлын бүртгэл болон өгсөн маягтын дагуу ажлын баримт бэлтгэж, нэгтгэх.

2.3. Бараа материалын зардал: Жилийн ажлын хөтөлбөр, төсөв, гүйцэтгэл, өртөг нөхөх зардлын тайланг анхан шатны баримттай тулган шалгана. Үүнд:

- Бараа материал болон түлшний анхан шатны баримтыг бараа материалын орлого, зарлагын тайлантай тулгах;
- Бараа материал болон түлшний худалдах, худалдан авах гэрээнд заасан бүтээгдэхүүнийг худалдан авсан эсэхийг тулгах;
- Бараа материал, түлшний зарцуулалтыг анхан шатны баримттай тулгах;
- Бараа материалын бэлэн мөнгөөр хийсэн гүйлгээний баримтыг тулгах;
- Гүйцэтгэлийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулсан эсэхийг тулгах;
- Бараа материал, түлшний зардлаас зориулалт бус зардал гаргасан эсэхийг тулгах;
- Асуудлын бүртгэл болон өгсөн маягтын дагуу ажлын баримт бэлтгэж нэгтгэх.

2.4. Үйлчилгээ /сервис/ болон өртөг нөхөгдөх зардалд тайлагнасан бусад зардал: Жилийн ажлын хөтөлбөр, төсөв, гүйцэтгэл, өртөг нөхөгдөх зардлын тайланг анхан шатны баримттай тулган шалгана. Үүнд:

- Үйлчилгээ болон өртөг нөхөгдөх зардалд тайлагнасан бусад зардлын гүйлгээ бүрийг анхан шатны баримттай тулган баталгаажуулах;
- Үйлчилгээ болон өртөг нөхөгдөх зардалд тайлагнасан бусад зардлын гүйлгээ бүр бүтээгдэхүүн хуваах гэрээ, холбогдох журам, заавар, харилцагч байгууллагуудтай байгуулсан гэрээний заалтуудтай нийцэж буй эсэхийг тулган шалгах;
- Үйлчилгээ болон өртөг нөхөгдөх зардалд тайлагнасан бусад зардлын гүйцэтгэл батлагдсан төсвийн дагуу эсэхийг тулган шалгах.

3. Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн 2020-2021 оны борлуулалтын орлогын журналыг нэхэмжлэх, дансны хуулгаарх орлогоос Монгол Улсын Засгийн газарт зөв хуваарилсан эсэхийг хянан баталгаажуулах;

Гүйцэтгэх ажил:

1, 2 дугаар ажлыг баталгаажуулсан дүнд үндэслэн ашигт газрын тосыг Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу тооцон хувааж, улсын төсвийн орлогыг хугацаанд нь төвлөрүүлсэн эсэхэд тооцоолол хийнэ.

4. Гэрээлэгчийн ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг баталж, түүний гүйцэтгэлд хяналт тавьсан эсэхэд дүгнэлт гаргана.

Гүйцэтгэх ажил:

1, 2 дугаартай ажлуудын баталгаажуулах явцад АМГТГ-аас гэрээлэгчийн ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг баталж, түүний гүйцэтгэлд хяналт тавьсан эсэхийг шалгаж, дүгнэлт гаргана.

5. Гэрээлэгчийн 2020-2021 оны нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалттай холбоотой тайлан мэдээг хүлээн авч, хяналт тавьсан эсэхэд дүгнэлт гаргана.

Гүйцэтгэх ажил:

1, 2 дугаартай ажлуудын баталгаажуулах явцад АМГТГ-аас гэрээлэгчийн хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт,

борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалттай холбоотой тайлан мэдээг хүлээн авч, хяналт тавьсан эсэхийг шалгаж, дүгнэлт гаргана.

Аудитын явцад илэрсэн нөхцөл байдалд нэмэлт горим, сорил хэрэгжүүлж болно.

ГУРАВ. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Аудитын хүрээнд бүтээгдэхүүн хуваах гэрээгээр газрын тосны олборлолт, экспортын үйл ажиллагаа эрхэлж буй Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн 2020-2021 онд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардал, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын холбогдох тайлан, өртөг нөхөгдөх зардлын тайлан, мэдээ, анхан шатны баримт, шаардлагатай бусад баримтуудыг хамруулна.

ДӨРӨВ. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН, БҮТЭЭГДЭХҮҮН

Аудит гүйцэтгэх хуулийн этгээдийн ажлын гүйцэтгэлээр дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

АУДИТЫН ҮЕ ШАТ	Гүйцэтгэл	Хүлээгдэж буй үр дүн
Гүйцэтгэлийн үе шат	Гэрээлэгчийн олборлосон тосны хэмжээ /баррель/, Экспортолсон газрын тосны хэмжээ /баррель/, Борлуулалтын орлогын хэмжээ /ам доллар/, Борлуулалтын зардлын дүн, тоо хэмжээг түс түс баталгаажуулна.	Орлогын ажлын баримт, хүснэгтийг шалгадагч этгээдээр хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулсан байна.
	Орд ашиглалтын үйл ажиллагаатай холбоотой хөрөнгө оруулалтын зардал, үйлчилгээ, бараа материал, цалин, даатгал, оффис, бааз агуулахын зардал, үйл ажиллагаа, тээвэр, борлуулалт, хуулийн болон холбогдох бусад зардлыг баталгаажуулна.	Зарлагын ажлын баримт, хүснэгтийг шалгадагч этгээдээр хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулсан байна.
	МУЗГ-т 2020-2021 онд ноогдох роялти, тосны хуваалт, борлуулалтын орлого зэргийг үнэн зөв хуваарилсан эсэхийг хянан баталгаажуулах;	Гэрээлэгчийн тайланг аудитаар хянаж, тооцоолон баталгаажуулсан байна.
	Гэрээлэгчийн ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг баталж, түүний гүйцэтгэлд хяналт тавьсан эсэхэд дүгнэлт гаргана.	Жилийн үйл ажиллагааны хөтөлбөр, төсвийн маягтын дагуу төсөв, гүйцэтгэлийг гаргаж, шалгадагч этгээдээр хүлээн зөвшөөрүүлсэн байна. Төсөв, хөтөлбөрийг хэтрүүлэн болон дутуу хэрэгжүүлсэн, хэмнэсэн арга хэмжээ, зардлын талаар дүгнэлт гарсан байна.
	Гэрээлэгчийн 2020-2021 оны нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалттай холбоотой тайлан мэдээг хүлээн авч, хяналт тавьсан эсэхэд дүгнэлт гаргана.	Төрийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлсэн хяналтын талаар дүгнэлт гарсан байна. Асуудлын бүртгэлээр хүлээн зөвшөөрсөн дүгнэлт гарсан байна.
Тайлагналын үе шат	Аудитын тайлангийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэхэд оролцох.	Өртөг нөхөх зардлын тайлан, орлогын тайлан зэргийг баталгаажуулсан байна. Асуудлын шинжилгээний дагуу аудитын тайлан бичиж, аудитын менежер, газрын захирлаар хянуулж, баталгаажуулсан байна.

ТАВ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Аудитыг гэрээгээр гүйцэтгэх хуулийн этгээд нь тухайн аудитад оролцоход ашиг сонирхлын зөрчилгүй, хувь хүн, байгууллага, албаны болон төрийн нууцыг задруулахгүй

гэдгээ бүрэн илэрхийлж, нууцын баталгааг гаргаж, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн газрын багийн бүрэлдэхүүнтэй хамтарч ажиллана.

Тус ажлыг ажлын даалгаврын дагуу гүйцэтгэхээр шалгарсан аудитын хуулийн этгээд нь захиалагчийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан, аудитын багтай уулзалт, ярилцлага хийх, шаардлагатай асуудлаар нэмэлт тодруулга авч ажиллаж болно.

Үе шатны ажлын явцад бий болсон шийдвэрлэх боломжгүй асуудлыг тухай бүр захиалагч талын холбогдох албан тушаалтанд мэдэгдэнэ.

Аудитын явцад тавих чанарын хяналтыг аудитын хуулийн этгээд өөрийн хүрээнд иж бүрэн гүйцэтгэхээс гадна аудитын явц, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг Үндэсний аудитын газарт хүргүүлж, аудитыг нэгтгэн удирдах боломжоор хангана.

ЗУРГАА. ТАВИГДАХ ШААРДЛАГА БОЛОН АЖЛЫН ТУРШЛАГА

Аудитыг гүйцэтгэх хуулийн этгээд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Баталгаажуулалт, Аудит, Нягтлан бодох бүртгэл, зөвлөх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй байх;
- Аудиторууд нь мэргэжлийн ёс зүйн зөрчилгүй байх;
- Үйл ажиллагаа явуулах ажлын байр, техник хэрэгсэлтэй;
- Аудитын багийн гишүүд нь үйлчлүүлэгчийн эрх бүхий аль нэг албан тушаалтантай хамааралгүй байх.

Хүний нөөцийн шаардлага:

- 6-аас доошгүй үндсэн орон тооны, хугацаагүй эрхтэй мэргэшсэн нягтлан бодогчтой байх;
- Аудитын байгууллагад ажилладаг мэргэшсэн нягтлан бодогч өөр байгууллагад давхар ажил эрхлэх, бусад аудитын хуулийн этгээдэд гэрээгээр ажилладаггүй байх;
- Гэрээгээр гүйцэтгэж байсан бусад ажлын жагсаалт.

Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гэрээ, ажлын даалгаварт заасан ажлыг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд хийж шаардлагатай судалгаа, шинжилгээ, тооцоо, тайлан бусад ажлыг хугацаанд нь үнэн зөв чанартай хийж гүйцэтгэнэ.


ДОЛОО. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Төлбөрийн нөхцөлийг ажлын гүйцэтгэлд үндэслэн гэрээнд заасан нөхцөл, хуваарийн дагуу олгоно.

Хянасан:


САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР



Д.ОТГОНБАЯР

Боловсруулсан:

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР




Б.АНХБААТАР

Ц.БАТСҮХ

Ц.ЦЭРЭННАМЖИЛ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ТАМГЫН ДАРГА



БАТЛАВ:

С.ЦЭРЭНБАЯР

Огноо: 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр

“ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРТ БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭГЭЭР
ОЛБОРЛОЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ДОНШЕН ГАЗРЫН ТОС (МОНГОЛ)
ХХК-ИЙН 2020-2021 ОНЫ БАТЛАГДСАН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСВИЙН ДАГУУ ХИЙЖ
ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ӨРТӨГ НӨХСӨН БОЛОН
НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ, ГАЗРЫН ТОСНЫ ЭКСПОРТ, БОРЛУУЛАЛТЫН
ОРЛОГЫН ТООЦОО, ХУВААРИЛАЛТАД БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙХ АУДИТ”-ЫН
ХҮРЭЭНД **“ГАЗРЫН ТОСНЫ ӨРТӨГ НӨХӨХ ЗАРДЛЫГ БАТАЛГААЖУУЛАХ
АУДИТЫН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ”**
ШИНЖЭЭЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ БАРИМТ БИЧИГ

УЛААНБААТАР ХОТ

2022 он

БАРИМТ БИЧГИЙН БҮРДЭЛ

- МАЯГТ 1-САНАЛЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ
- МАЯГТ 2-ОРОЛЦОХ ХҮСЭЛТ
- МАЯГТ 3-ОРОЛЦОГЧИЙН ТАНИЛЦУУЛГА
- МАЯГТ 4-САНАЛ БОЛГОЖ БУЙ МЭРГЭЖИЛТНИЙ НАМТАР(CV)-ЫН ЖИШИГ ХҮСНЭГТ
- МАЯГТ 5-АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД ШААРДАГДАХ АЖЛЫН БАЙР, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ
- МАЯГТ 6-БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН БОЛОН АЖЛЫН ХУВААРИЛАЛТ
- МАЯГТ 7-АЖЛЫН ХӨТӨЛБӨР БОЛОН АРГАЧЛАЛЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА
- МАЯГТ 8-ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ
- МАЯГТ 9-ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ
- МАЯГТ 10-ШИНЖЭЭЧ АЖИЛЛУУЛАХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

САНАЛЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (СӨХ)

№	Ерөнхий зүйл
1	Захиалагч нь: [Захиалагч нь: Үндэсний аудитын газар 15160. Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын IV байр.]
2	Захиалагчийн оролцоо, үзүүлэх дэмжлэг, байр, тоног төхөөрөмж: Зөвлөх үйлчилгээ үзүүлж буй шинжээчийн баг, хуулийн этгээд нь Үндэсний аудитын газартай гэрээ байгуулан ажиллах ба тус газрын Аудитын гуравдугаар газрын аудитын багтай хамтран ажиллаж, шаардлагатай дэмжлэг, туслалцааг тус газраас үзүүлнэ. Шинжээч нь аудитын явцад олж авсан болон мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийн нууцлалыг хадгалах ба гэрээгээр тохиролцсон ажилд оролцож дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд шударгаар ажиллаж, төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг нэгэн адил даган мөрдөж ажиллана. Шинжээч нь хууль тогтоомжид нийцсэн шаардлагын дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн мэдэгдлийг гаргаж, албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдал үүсвэл эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх бөгөөд Үндэсний аудитын газартай иж бүрэн түншлэлийн чиглэлээр нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.
3	Шинжээчийн үйлчилгээг цаашид үргэлжлүүлэн гүйцэтгэх шаардлагатай эсэх: “үгүй”
4	Санал хүлээн авах хугацаанаас 2 хоногийн өмнө албан бичгээр ирсэн тодруулгад хариу өгнө. Үндэсний аудитын газар. Захиргаа, хууль, эрх зүйн газрын худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Н.Цэнд-Аюуш. tsend-ayushn@audit.gov.mn. Гар утас: 88051068.
5	Саналыг Монгол хэлээр ирүүлнэ.
6	Хураангуй жагсаалтад орсон шинжээч эсхүл хуулийн этгээд мөн жагсаалтад орсон бусад компанитай хамтран ажиллаж болно: “хамааралгүй”
7	Шинжээчийн ажил үйлчилгээ ажлын даалгаварт тусгасан өдөрт багтаан гүйцэтгэнэ.
	<u>Гүйцэтгэх ажлын үнийн санал</u> Гүйцэтгүүлэх ажлын төсөвт өртөг: 11 133 600 /арван нэгэн сая нэг зуун гучин гурван мянга зургаан зуун/ төгрөг байна. Шинжээчийн ажлыг гүйцэтгэх гэж буй зөвлөх нь ҮНЭ-ийг санал болгохдоо ажлын даалгаварт тусгагдсан ажилбар тус бүрийг тооцоолж, саналаа ирүүлэх шаардлагатай. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ, ҮҮРЭГ Аудитыг гүйцэтгэх хуулийн этгээд нь Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу ажлын даалгаварт заасан ажлыг АДБОУС, Бүтээгдэхүүн хуваах гэрээ, хууль, журам болон бусад баримт бичигт нийцүүлэн цаг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэх үүрэгтэй. Ажлын зорилтын хүрээнд Үндэсний аудитын газар, Ашигт малтмал, газрын тосны газар болон Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн ажлын байранд тус тус ажиллана. Бэлтгэсэн ажлын баримт материалд тулгуурлан ажлын даалгаварт тусгасан ажлыг гүйцэтгэж, аудитын гүйцэтгэлийн болон тайлагналын үе шатны шаардлагатай мэдээллээр дэд тайлан бэлтгэнэ. Үүнд:

1. Гэрээлэгчийн олборлосон тосны хэмжээ /баррель/, Экспортолсон газрын тосны хэмжээ /баррель/, Борлуулалтын орлогын хэмжээ /ам доллар/, Борлуулалтын зардлын дүн, тоо хэмжээг тус тус баталгаажуулна.

Гүйцэтгэх ажил: Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн 2020-2021 оны олборлосон газрын тос, экспортын газрын тосны хэмжээг дараах тоо хэмжээ, баримтад тулгуурлан баталгаажуулалт хийнэ. Үүнд:

Олборлолт:

- ☐ Олборлолтын төлөвлөгөө, гүйцэтгэл;
- ☐ Олборлолтын цооногуудаар олборлосон газрын тосны хэмжээ;
- ☐ Цооног шавхалтаар олборлосон тосны хэмжээ;
- ☐ Ус шахалтын үйл ажиллагаанд хэрэглэсэн ус.

Экспорт:

- ☐ Экспортолсон тосны ачилтын хэмжээ;
- ☐ Экспортолсон тосны буулгалтын хэмжээ;
- ☐ Усны агууламж, нягтын хэмжээ, тонн жин.

Протокол, олборлолтын өдөр тутмын мэдээ, ус шавхалтын өдөр тутмын мэдээ, анхан шатны баримт, гаалийн мэдээлэл зэрэг санхүүгийн баримт материалуудыг ашиглан дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

- ☐ Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн 2020-2021 оны борлуулалтын орлогын журналыг нэхэмжлэх, дансны хуулгатай тулган шалгах;
- ☐ АМГТГ-аас 2020-2021 оны олборлосон, экспортолсон газрын тосны хэмжээ, борлуулалтын орлого бүрдүүлэлт зэрэгт хяналт тавьсан эсэхийг тулган шалгах.

2. Орд ашиглалтын үйл ажиллагаатай холбоотой хөрөнгө оруулалтын зардал, үйлчилгээ, бараа материал, цалин, даатгал, оффис, бааз агуулахын зардал, Үйл ажиллагаа, тээвэр, борлуулалт, хуулийн болон өртөг нөхөгдөх зардлын тайланд тусгасан бусад зардлыг баталгаажуулна.

Гүйцэтгэх ажил:

- 2.1. Хөрөнгө оруулалтын зардал: Орд ашиглалтын ерөнхий төлөвлөгөө, жилийн ажлын хөтөлбөр, төсөв, гүйцэтгэл, өртөг нөхөх зардлын тайланг анхан шатны баримттай тулган шалгана. Үүнд:

- ☐ Анхан шатны баримтын шалгалт хийх;
- ☐ Тооцооллыг шалгах;
- ☐ Жишиг үнийн харьцуулалт хийх;
- ☐ Гэрээний гүйцэтгэл шалгах;
- ☐ Асуудлын бүртгэл болон өгсөн маягтын дагуу ажлын баримт бэлтгэж нэгтгэх.

- 2.2. Цалин, даатгалын зардал: Жилийн ажлын хөтөлбөр, төсөв, гүйцэтгэл, өртөг нөхөх зардлын тайланг анхан шатны баримттай тулган шалгана. Үүнд:

- ☐ Өртөг нөхөх зардлын тайланд тусгасан цалин, даатгалын зардлыг анхан шатны баримттай тулган баталгаажуулах;

- ☐ Анхан шатны баримтад тусгасан Монгол, Хятад ажилтнуудын цалингийн тооцооны хүснэгтээс цалингийн тооцоолол, нэмэгдэл, урамшууллын үндэслэлийг давтан тооцоолж, тулган баталгаажуулах;
- ☐ Цагийн бүртгэл, ажилд томилсон, чөлөөлсөн тушаал шийдвэрийн үндэслэлийг анхан шатны баримтад үндэслэн тулгах;
- ☐ Монгол, Хятад ажилтнуудын цалингаас Хувь хүний орлогын албан татварын тухай, Нийгмийн даатгалын тухай хуулиудын дагуу суутгасан хувь хүний орлогын албан татварын болон нийгмийн даатгалын шимтгэлийн суутгалыг тулган баталгаажуулах;
- ☐ Тус компани нь 2020-2021 онд БНХАУ-аас хичнээн иргэнийг хөдөлмөр эрхлүүлэхээр Монгол Улсад оруулж ирснийг холбогдох судалгаатай тулгах, /ҮАГ тус судалгааг Хөдөлмөр, халамж, үйлчилгээний ерөнхий газраас авч өгөх/
- ☐ Дээрх Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн нэр дээр хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авч орж ирсэн БНХАУ-ын иргэдийн хөдөлмөрийн харилцаа, цалин хөлсний үндэслэл, татвар, даатгалын харилцаа нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг тогтоох;
- ☐ Удирдлагын зардалд хамаарах өөрөөр хэлбэл Монгол Улсад түр ажилласан, толгой компанид бүртгэлтэй ажилтнуудад тус компаниас олгосон цалингийн зардлыг өртөг нөхөн зардлаас хасаж тооцох;
- ☐ Монгол Улсын болон БНХАУ-ын ажилтнуудын цалинг тооцож олгож байгаа журам, шийдвэр нь Газрын тосны тухай хуульд хэрхэн нийцэж байгаа талаар тулган шалгаж, дүгнэлт гаргах;
- ☐ Асуудлын бүртгэл болон өгсөн маягтын дагуу ажлын баримт бэлтгэж, нэгтгэх.

2.3. Бараа материалын зардал: Жилийн ажлын хөтөлбөр, төсөв, гүйцэтгэл, өртөг нөхөх зардлын тайланг анхан шатны баримттай тулган шалгана. Үүнд:

- ☐ Бараа материал болон түлшний анхан шатны баримтыг бараа материалын орлого, зарлагын тайлантай тулгах;
- ☐ Бараа материал болон түлшний худалдах, худалдан авах гэрээнд заасан бүтээгдэхүүнийг худалдан авсан эсэхийг тулгах;
- ☐ Бараа материал, түлшний зарцуулалтыг анхан шатны баримттай тулгах;
- ☐ Бараа материалын бэлэн мөнгөөр хийсэн гүйлгээний баримтыг тулгах;
- ☐ Гүйцэтгэлийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулсан эсэхийг тулгах;
- ☐ Бараа материал, түлшний зардлаас зориулалт бус зардал гаргасан эсэхийг тулгах;
- ☐ Асуудлын бүртгэл болон өгсөн маягтын дагуу ажлын баримт бэлтгэж нэгтгэх.

2.4. Үйлчилгээ /сервис/ болон өртөг нөхөгдөх зардалд тайлагнасан бусад зардал: Жилийн ажлын хөтөлбөр, төсөв, гүйцэтгэл, өртөг нөхөгдөх зардлын тайланг анхан шатны баримттай тулган шалгана. Үүнд:

- ☐ Үйлчилгээ болон өртөг нөхөгдөх зардалд тайлагнасан бусад зардлын гүйлгээ бүрийг анхан шатны баримттай тулган баталгаажуулах;
- ☐ Үйлчилгээ болон өртөг нөхөгдөх зардалд тайлагнасан бусад зардлын гүйлгээ бүр бүтээгдэхүүн хуваах гэрээ, холбогдох журам, заавар, харилцагч байгууллагуудтай байгуулсан гэрээний заалтуудтай нийцэж буй эсэхийг тулган шалгах;
- ☐ Үйлчилгээ болон өртөг нөхөгдөх зардалд тайлагнасан бусад зардлын гүйцэтгэл батлагдсан төсвийн дагуу эсэхийг тулган шалгах.

	3. Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн 2020-2021 оны борлуулалтын орлогын журналыг нэхэмжлэх, дансны хуулгаарх орлогоос Монгол Улсын Засгийн газарт зөв хуваарилсан эсэхийг хянан баталгаажуулах; Гүйцэтгэх ажил: 1, 2 дугаар ажлыг баталгаажуулсан дүнд үндэслэн ашигт газрын тосыг Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу тооцон хувааж, улсын төсвийн орлогыг хугацаанд нь төвлөрүүлсэн эсэхэд тооцоолол хийнэ. 4. Гэрээлэгчийн ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг баталж, түүний гүйцэтгэлд хяналт тавьсан эсэхэд дүгнэлт гаргана. Гүйцэтгэх ажил: 1, 2 дугаартай ажлуудын баталгаажуулах явцад АМГТГ-аас гэрээлэгчийн ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг баталж, түүний гүйцэтгэлд хяналт тавьсан эсэхийг шалгаж, дүгнэлт гаргана. 5. Гэрээлэгчийн 2020-2021 оны нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалттай холбоотой тайлан мэдээг хүлээн авч, хяналт тавьсан эсэхэд дүгнэлт гаргана. Гүйцэтгэх ажил: 1, 2 дугаартай ажлуудын баталгаажуулах явцад АМГТГ-аас гэрээлэгчийн хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалттай холбоотой тайлан мэдээг хүлээн авч, хяналт тавьсан эсэхийг шалгаж, дүгнэлт гаргана. Аудитын явцад илэрсэн нөхцөл байдалд нэмэлт горим, сорил хэрэгжүүлж болно. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ Аудитын хүрээнд бүтээгдэхүүн хуваах гэрээгээр газрын тосны олборлолт, экспортын үйл ажиллагаа эрхэлж буй Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн 2020-2021 онд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардал, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын холбогдох тайлан, өртөг нөхөгдөх зардлын тайлан, мэдээ, анхан шатны баримт, шаардлагатай бусад баримтуудыг хамруулна.
9	Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх, шинжээч нь дээрх зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхээ илэрхийлсэн албан хүсэлт ирүүлэхээс гадна дараах үндсэн мэдээллийг баталгаажуулан ирүүлнэ. Үүнд: Хуулийн этгээд бол: - Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар; - Татварын өргүй тухай тодорхойлолт; - Нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тодорхойлолт; - Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт; - Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл сүүлийн 3 жилээр /2019, 2020, 2021 он/; - Ажилтны анкет, боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар; - Ажилтны нийгмийн даатгалын цахим лавлагаа /сүүлийн 1 жилээр/; - Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт /2020, 2021 оны жилийн эцсийн/. Мөн баримт бичигт хавсаргасан дараахь маягтаар саналаа илэрхийлсэн байна. Үүнд: - Оролцох хүсэлтийн маягт. /Маягт 2/ - Оролцогчийн танилцуулга. /Маягт3/ - Санал болгож буй мэргэжилтний намтар(CV). /Маягт 4/ - Ажил гүйцэтгэхэд шаардагдах ажлын байр, тоног төхөөрөмж. /Маягт 5/ - Багийн бүрэлдэхүүн болон ажлын хуваарилалт. /Маягт 6/ - Ажлын хөтөлбөр болон аргачлалын талаарх танилцуулга /Маягт 7/

	Шинжээчид тавигдах шаардлага, ажлын туршлага: Аудитыг гүйцэтгэх хуулийн этгээд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд: • Баталгаажуулалт, Аудит, Нягтлан бодох бүртгэл, зөвлөх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй байх; • Аудиторууд нь мэргэжлийн ёс зүйн зөрчилгүй байх; • Үйл ажиллагаа явуулах ажлын байр, техник хэрэгсэлтэй; • Аудитын багийн гишүүд нь үйлчлүүлэгчийн эрх бүхий аль нэг албан тушаалтантай хамааралгүй байх. Хүний нөөцийн шаардлага: • 6-аас доошгүй үндсэн орон тооны, хугацаагүй эрхтэй мэргэшсэн нягтлан бодогчтой байх; • Аудитын байгууллагад ажилладаг мэргэшсэн нягтлан бодогч өөр байгууллагад давхар ажил эрхлэх, бусад аудитын хуулийн этгээдэд гэрээгээр ажилладаггүй байх; • Гэрээгээр гүйцэтгэж байсан бусад ажлын жагсаалт. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гэрээ, ажлын даалгаварт заасан ажлыг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд хийж шаардлагатай судалгаа, шинжилгээ, тооцоо, тайлан бусад ажлыг хугацаанд нь үнэн зөв чанартай хийж гүйцэтгэнэ.
10	Шинжээчийн үйлчилгээний хүрээнд хийгдэх тайланг Монгол хэлээр бэлтгэнэ.
11	Ажлын даалгаварт заасан бусад нэмэлт шаардлага. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гэрээ, ажлын даалгаварт заасан ажлыг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, шаардлагатай судалгаа, шинжилгээ, тооцоо, тайлан бусад ажлыг хугацаанд нь үнэн зөв чанартай хийж гүйцэтгэнэ.
12	Татвар [Гүйцэтгэгч, тэдгээрийн ажиллах хүчин нь холбогдох хуулийн дагуу төлбөл зохих татвар, хураамж болон төлбөрийг төлөх ёстой. Иймд гэрээт ажлын хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэл болон хувь хүний орлогын албан татварыг ажил олгогчийн зүгээс суутган тооцно. Гүйцэтгэгч нь гэрээнд заагдсан төлбөрийн хуваарийн дагуу цахим төлбөрийн баримтын системд төлбөрийн нэхэмжлэл үүсгэсэн үед төлбөрийг шилжүүлнэ].
13	Санал ирүүлэх тоо: эх хувь 1
14	Санал ирүүлэх хаяг: Цахимаар Үндэсний аудитын газар. Захиргаа, хууль, эрх зүйн газрын худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Н.Цэнд-Аюуш. tsend-ayushn@audit.gov.mn. Гар утас: 88051068.
15	Саналыг 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 17 цаг 30 минутаас өмнө ирүүлсэн байна.
16	(а) Төсөвт өртөг нь 50 сая ба түүнээс дээш өртөгтэй тул ажил гүйцэтгүүлэх тохиолдолд гүйцэтгэлийн баталгаа шаардана. (б) Гүйцэтгэлийн баталгааг зохих маягтын дагуу гэрээнд гарын үсэг зурахаас өмнө захиалагчид ирүүлэх бөгөөд гүйцэтгэлийн баталгааны хэмжээ буюу мөнгөн дүн нь санал болгосон үнэ буюу гэрээний үнийн дүнгийн 5 хувиас багагүй байна. Гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй нь гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгох үндэслэл болно.

ОРОЛЦОХ ХҮСЭЛТИЙН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

Танай [он, сар, өдөр]-ийн шинжээч сонгон шалгаруулах зар/урилга болон өөрсдийн оролцох хүсэлтийн дагуу бид [Шинжээчийн үйлчилгээний нэр]-г _____ төгрөгөөр гүйцэтгэх саналыг үүгээр хүргүүлж байна. /төсвийн тооцоололыг хавсарган/

Гэрээний хэлэлцээрийн үр дүнд өөрчлөлт оруулахаас бусад тохиолдолд энэхүү санал өөрчлөгдөхгүй.

Ирсэн аливаа саналаас та татгалзах эрхтэй болохыг бид хүлээн зөвшөөрч байна.

Хүндэтгэсэн,

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг: _____

Холбоо барих утас: _____

ОРОЛЦОГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

3.1. Ерөнхий танилцуулга

.....

 (Оролцогч хуулийн этгээд нь ерөнхий танилцуулгад холбогдох үйл ажиллагаа явуулах бүртгэлийн болон эрхийн гэрчилгээг хавсаргаж ирүүлнэ)

3.2. Хуулийн этгээд/баг/хувь хүний чадварыг харуулж чадах сүүлийн 3 жилд үзүүлсэн ижил, төстэй үйлчилгээний мэдээлэл

Доорх хүснэгтийн дагуу хуулийн этгээд нь дангаараа болон хамтарч албан ёсоор үзүүлсэн үйлчилгээ бүрийн тухай мэдээлнэ үү. Нотлох баримтыг хавсарган ирүүлэх шаардлагатай.

Гүйцэтгэсэн ажлын нэр:		Улсын нэр:
Байршил:		Танай байгууллагаас ажилласан мэргэжилтэн (чиглэл):
Захиалагчийн нэр:		Ажилтны тоо:
Хаяг:		Гүйцэтгэсэн ажлын хугацаа, хүн-сарын тоо:
Эхэлсэн он сар өдөр:	Дууссан он сар өдөр:	Ажлын өртөг (сая төгрөгөөр) ойролцоогоор:
Түншлэн ажилласан гүйцэтгэгчийн нэр (хэрэв байвал):		Түншлэн ажилласан гүйцэтгэгчийн ажилтнуудын ажилласан сарын тоо:
Голлох мэргэжилтэн: (Төслийн удирдагч/зохицуулагч, төслийн ахлагч)-ийн гүйцэтгэсэн ажил, үүргүүд:		
Төслийн талаарх товч танилцуулга:		
Төслийн хүрээнд танай ажилтны гүйцэтгэсэн үндсэн үйлчилгээний талаарх танилцуулга:		

Хуулийн этгээд/баг/хувь хүний нэр: _____

САНАЛ БОЛГОЖ БУЙ МЭРГЭЖИЛТНИЙ НАМТАР(CV)-ЫН ЖИШИГ МАЯГТ

Санал болгож буй албан тушаал: _____

Байгууллагын нэр: _____

Мэргэжилтний нэр: _____

Мэргэжил: _____

Төрсөн он, сар, өдөр: _____

Тухайн байгууллагад ажилласан жил: _____ Иргэншил: _____

Мэргэжлийн холбооны гишүүнчлэл: _____

Хариуцах ажил: _____

Ур чадварын:

[Хариуцах ажлын чиглэлээр туршлагажсан, сургалтад хамрагдсан байдлыг товч харуулна. Өмнө гүйцэтгэж байсан ижил төрлийн үйлчилгээнд хариуцаж байсан ажил, хугацаа, байршлыг зааж харуулах. Эдгээр мэдээллийг хагас хуудсанд багтааж бичнэ.]

Боловсрол:

[Мэргэжилтний их, дээд сургууль, коллеж болон бусад эзэмшсэн мэргэжлийн боловсролын байдал, сургуулийн нэрс, оролцсон/дүүргэсэн хугацаа болон хамгаалсан эрдмийн зэргийн хамт нэгтгэж харуулах. Эдгээр мэдээллийг хуудасны дөрөвний нэгт багтааж бичнэ.

Мөн нотлох баримтыг материалд хавсарган ирүүлэх шаардлагатай]

Ажилласан туршлага:

[Өнөөгийн байдлаас эхлэн эсрэг дарааллаар ажилласан туршлагыг бич. Сургууль төгссөнөөс хойш ажилласан бүх албан тушаалын нэр, ажил эрхэлсэн хугацаа, ажил олгогч байгууллага, байршил зэргийг бичнэ. Сүүлийн 10 жилийн туршлагын хувьд гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ болон шаардлагатай бол харилцагчийн тодорхойлолтыг хавсаргана. Эдгээр мэдээллийг бичгийн 2 хуудсанд багтаан бичнэ.]

Хэлний мэдлэг:

[Эзэмшсэн хэлний мэдлэгийн түвшнийг ярих, унших, бичих тус бүрд онц, сайн, дунд эсхүл муу гэж тодорхойлно.]

Батламж:

Дээрх мэдээлэл нь миний мэдлэг, чадвар, туршлагыг үнэн зөв харуулсан болохыг үүгээр баталж байна.

Мэргэжилтний овог, нэр, гарын үсэг: _____ Огноо: _____

Эрх бүхий этгээдийн овог, нэр, гарын үсэг: _____ Огноо: _____

**АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД ШААРДАГДАХ АЖЛЫН БАЙР,
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ¹**

№	Нэр	Хаяг, байршил	Хүчин чадал
1	Ажлын байр		
2	Тоног төхөөрөмж		

БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН БОЛОН АЖЛЫН ХУВААРИЛАЛТ

№	Нэр	Албан тушаал	Хариуцах ажил

АЖЛЫН ХӨТӨЛБӨР БОЛОН АРГАЧЛАЛЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

- *Ажлын хөтөлбөрийг дэлгэрэнгүй байдлаар хүснэгтээр гаргаж ирүүлнэ. Үүнд:*
-

№	Хийх ажилбар	Хэрэгжүүлэх хугацаа					Хариуцах ажилтан
		... хоног	... хоног			гэх мэт	

- *Ажил гүйцэтгэх аргачлалыг ажлын даалгаврыг үндэслэн дэлгэрэнгүй гаргаж ирүүлнэ.*

Баталгаажуулах

¹ Ажлын байр, тоног төхөөрөмжийн зургийг хавсаргаж ирүүлнэ.